



ДУНДГОВЬ АЙМАГ

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2023 ОНЫ БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН
ТАЙЛАН

АГУУЛГА

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго	3
Хоёр. Хяналт шинжилгээ, үнэлгээний үндэслэл, арга зүй.....	3
Гурав.Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.....	3-8
Дөрөв. Дүгнэлт	9-14
Тав. Санал, зөвлөмж	14-15

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2024 оны 02 сарын 26

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Аймгийн Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, хүрсэн түвшнийг тусгагдсан зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлттэй харьцуулан үр дүнг үнэлэх, гарсан дүгнэлт зөвлөмжийг дараагийн шийдвэр, бодлого төлөвлөлтөд тусгах, үр нөлөөг нэмэгдүүлэх, удаашралтай хэрэгжиж байгаа зорилт, арга хэмжээг эрчимжүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

ХОЁР.ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу 2023 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6.2.1, 6.2.2, 6.2.3-т заасан арга зүйгээр төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ ирүүлсэн тайлангаас гадна иргэдэд ил тод мэдээлсэн эх сурвалжийн мэдээлэл, газар дээр нь очиж танилцах, нотлох баримтад үндэслэх, статистик мэдээлэлтэй тулган үзэх, холбогдох хэлтэс, алба, нэгжээс нэмэлт тодруулга авах, мэдээлэлтэй тулган үзэх замаар зэргээр хэрэгжилтийг баталгаажуулж, 40 зорилтын 140 арга хэмжээний дундаж үнэлгээгээр үнэлгээ хийсэн болно.

ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний Бодлогын баримт бичиг болон хуулиар олгосон чиг үүргийн зорилтын хүрээнд 17 зорилт, 63 арга хэмжээ төлөвлөснөөс 17 зорилтын дундаж 98,2 хувьтай, 63 арга хэмжээний дундаж 96,5 хувьтай, Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд 23 зорилт, 77 арга хэмжээ төлөвлөснөөс 23 зорилтын дундаж 95,5 хувьтай, 77 арга хэмжээний дундаж 96,1 хувьтай байна.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянан үзэж, өөрийн үнэлгээг **96,3 хувиар** үнэлэв.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ, 2023 он

№	Үндсэн чиглэл	Зорилт	Арга хэмжээ	Биелэлтийн хувь						Дундаж үнэлгээ /%/
				Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн		Эрчимжүүлэх шаардлагатай		Үр дүнгүй	
					100	90	70	50		
1	Бодлогын баримт бичиг болон хуулиар олгосон чиг үүргийн зорилтын хүрээнд	17	63	55	1	7				96,5
2	Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд	23	77	67	0	10				96,1
Нийт		40	140	122	1	17				96,3

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээг тус оны 6 сард хийж, зорилт, арга хэмжээний дундаж 90,04 хувьтай, хугацаа болоогүй 15 арга хэмжээ, 0 хувьтай 10 арга хэмжээ байгааг эрчимжүүлж ажиллах чиглэл өгч, зөвлөн тусалж ажилласнаар жилийн эцэст 6,3 хувиар өссөн байна.

Тус онд зөвлөмжийг хэрэгжүүлж, үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор “Төлөвлөлт ба тайлагналтад анхаарах асуудал” сэдвээр нийт хэлтэс, албадын албан хаагчдад сургалт зохион байгуулж, ганцаарчилсан зөвлөмжийг мөн хэлтэс бүрийн албан хаагчдад өгч ажилласнаар төлөвлөлт, тайлагналтын чанар эрс сайжирч байна.

2023 ОНД ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ОНЦЛОХ АЖЛУУД:

Дундговь аймгийн хүний хөгжлийн индекс Статистикийн үндэсний хорооны сүүлийн үеийн мэдээгээр 0.713 байгаа нь өмнөх оноос 0,006 индексээр өссөн үзүүлэлттэй байна.



Аймгийн хүн амын дундаж наслалт 74.7 байна. Энэ нь улсын дунджаас 3,4 насаар илүү ба улсад эхний 3-т эрэмбэлэгдэж байна.



Аймгийн эрэгтэй хүний дундаж наслалт 70,9, эмэгтэй хүний дундаж наслалт 80 болж дундаж наслалтын зөрүү 9,1 байна.

"Дундговь-боловсролын чанар" төсөл хэрэгжүүлж ажиллалаа.


Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр захирамжаар "Боловсролын чанар хүртээмжийг дэмжих жил" болгон зарлан "Дундговь-боловсролын чанар" төслийг аймгийн ИТХ-ын 2022 оны 61 дүгээр тогтоолоор 300,0 сая төгрөгийн санхүүжилт баталж, хэрэгжүүлэн төслийн хэрэгжилт 88,7 хувийн гүйцэтгэлтэй дүгнэгдэв.



Глобал удирдагч их сургууль, МУБИС, ерөнхий боловсролын оюунлаг сургуультай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав.



“ЭЕШ-2023” шалгалтад математик, физик, монгол хэл, түүх, нийгмийн ухааны хичээлүүд улсын дунджаас 10-18 оноогоор өндөр, өмнөх жилийн аймгийн дунджийг 1.4-12 оноогоор ахиулсан. Улсад 10-р байрт эрэмбэлэгдсэн амжилт гаргалаа.



Хүний нөөцийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд оюутнуудын сургалтын төлбөрийг хариуцан, орон нутагтаа ажиллах гэрээ хийж, хүний нөөцөө тогтвор суурьшилтай ажиллахад анхаарч байна.



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ - WELCOME TO DUNDGOVI МЭДЭЭЛЛИЙН ТӨВИЙГ БАЙГУУЛЛАА

Аялал жуулчлалын мэдээллийн төвийг шинээр байгуулж, гадаад, дотоодын 1368 жуулчинд үйлчилгээ үзүүлсэн. Мөн “Дундговь” аялал жуулчлал, бизнес эрхлэлтийг дэмжсэн гар утасны апплейкэйшн, платформыг хүлээн авч, сурталчлан ажилласан бөгөөд 206 иргэн гар утсандаа татаж суулган ашиглаж байна.



УЯХАН ЗАМБУУ ТИВИЙН НАРАН" УРТЫН ДУУ, МОРИН ХУУРЧДЫН ИХ НААДМЫГ 47000 ХҮН ҮЗЭЖ СОНИРХЛОО

“Уяхан замбуу тивийн наран” уртын дууч, морин хуурчдын их наадмыг байгалийн задгай театрт зохион байгуулж, нутгийн 55-аас дээш насны ахмад 1176, хүүхэд 706, 19-54 насны авьяастан 1218 нийтдээ 3100 авьяастныг сургаж, хамрууллаа. Улсын хэмжээнд хамгийн олон үзэгчтэй наадмаар тодорхойлогдож, 47 мянган иргэнд нутгийн үнэт өв соёлыг түгээн сурталчилж чадлаа.



“Иргэдийн төсөв-2023 эмхэтгэл” 500 ширхгийг боловсруулан Дэлхийн банкны төслийн ажилтнаар хянуулан баталгаажуулж, иргэдийг мэдээллээр хангалаа. Мөн цахим ном (online flip) хэлбэрээр гаргаж, dundgovi.gov.mn, dundgovi.khural.mn, montsame.mn сайт Дундговь аймгийн Засаг даргын тамгын газар, Гэрэлтдэг ертөнц фэйсбүүк хуудаст байршуулан 24 удаа дамжуулан цахим орчинд түгээсэн байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2023 оны 2 зорилтын хэрэгжилтийг хянан үнэлээд өөрийн үнэлгээгээр 96,3% буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэлээ.


Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг жил бүр нэгжийн төлөвлөгөөний хэрэгжилттэй нийцэж байгаа эсэхэд шинжилгээ хийж, харьцуулан дараа жилийн төлөвлөлтөд зөвлөмж өгч ажиллаж байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 40 зорилт, 140 арга хэмжээг шалгуур үзүүлэлтийн дагуу суурь түвшин, зорилтот түвшин, хүрсэн түвшинг харьцуулан хяналт шинжилгээ, үнэлгээг хийхэд Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт бусад нэгжээс доогуур хэрэгжиж байна.

№	Агуулга	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Арга хэмжээний биелэлт	Дундаж хувь
Бодлогын баримт бичиг болон хуулиар олгосон чиг үүргийн зорилтын хүрээнд					96,3
1	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	2	5	100	
2	Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс	11	32	93,1	
3	Санхүү төрийн сангийн хэлтэс	2	10	100	
4	Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэс	1	10	100	
5	Хууль, эрх зүйн хэлтэс	-	-	-	
6	Нийгмийн бодлогын хэлтэс	-	-	-	
7	Цэргийн штаб	1	6	100	
Дүн		98,2	63	96,5	
Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд					
1	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	2	16	100	
2	Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс	4	8	88,7	
3	Санхүү төрийн сангийн хэлтэс	2	6	100	
4	Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэс	2	6	100	
5	Хууль, эрх зүйн хэлтэс	5	12	100	
6	Нийгмийн бодлогын хэлтэс	7	27	92,2	
7	Цэргийн штаб	1	2	100	
Дүн		95,5	77	96,1	


Эхний хагас жилийн хугацаа болоогүй 15 арга хэмжээ, 0 хувьтай 10 арга хэмжээ байгааг эрчимжүүлж ажиллах чиглэл өгч, зөвлөн тусалж ажилласнаар жилийн эцэст 6,3 хувиар өссөн ба жилийн эцсээр хэрэгжээгүй буюу үр дүнгүй, эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийн гараагүй байна.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлтийн шатанд хяналт шинжилгээ хийж, зөвлөмж өгч ажилласнаар төлөвлөлтийн чанар дээшилсэн.

Байгууллагын нэгжүүдийн үнэлгээг харьцуулж үзэхэд Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт бусад нэгжээс доогуур хэрэгжиж байгаа хэдий ч Нийгмийн бодлогын хэлтсийн төлөвлөсөн ажлын хэрэгжилт өмнөх оноос 4,6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.




Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2 үндсэн чиглэлийн хүрээнд хэрэгжилтийг өмнөх онуудтай харьцуулалт хийж үзэхэд 2023 онд бодлогын баримт бичиг болон хуулиар олгосон чиг үүргийг ахицтай хэрэгжүүлсэн байна.



Төсөв санхүүгийн шинжилгээ

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 2023 онд нийт 22 тэрбум 307.5 сая төгрөг зарцуулсан байна. Үүнээс: Улсын төсвийн хөрөнгөөр 15 тэрбум 992 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 5 тэрбум, 557,9 сая төгрөг, хандив тусламжаар 516 сая төгрөг, гадаадын зээл тусламж болон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх замаар 242,5 сая төгрөг зарцуулж хэрэгжүүлсэн байна.



Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн хэмжээг тооцож, эхний хагас жил, жилийн эцсийн төсөв зарцуулалтад анализ хийж үзэхэд эхний хагас жилд 3 тэрбум, 965 сая төгрөг, сүүлийн хагас жилд 18 тэрбум, 342,5 сая төгрөг зарцуулж, нийт зарцуулсан хөрөнгийн 18 хувийг эхний хагас жилд зарцуулсан байна.

Зарцуулсан хөрөнгийн хэмжээг зорилтын хүрээгээр харьцуулж гаргалаа.

№	Эх үүсвэр	Бодлогын баримт бичиг болон хуулиар олгосон чиг үүргийн зорилтын хүрээнд	Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд	Дүн
1	УТХО	1470,8	14520,3	15992
	ОНТ	2316,4	3241,5	5557,9
	Хувийн хэвшил, хандив	240,7	275,3	516,0
	Гадаадын хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр	232,5	10,0	242,5
нэгтгэл		4260,4	18047,1	22307,5

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 2023 онд өмнөх оноос 2.5 дахин бага төсөв зарцуулсан байна. Энэ нь өмнөх жилийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахад бодлогын баримт бичиг болон харьяа доод шатны газар, хэлтэс, албаны ажлыг төлөвлөлтөд хуулбарлан төлөвлөсөн байдалтай холбоотой.

Агуулга	Улсын төсөв	Орон нутгийн төсөв	Хандив тусламж	Төсөл хөтөлбөр	Нийт дүн
2022 он	33937,3	10388,9	1992,4	8884,0	55202,6
2023 он	15992.0	5557.9	516.0	242.5	22307.5

Зарцуулсан хөрөнгийн 81 хувийг төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна.

№	Агуулга	Улсын төсөв	Орон нутгийн төсөв	Хандив тусламж	Төсөл хөтөлбөр	Дүн
Бодлогын баримт бичиг болон хуулиар олгосон чиг үүргийн зорилтын хүрээнд						
1	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	13,8	805,9	-	-	819,7
2	Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс	1457,0	1454,0	240,7	232,5	3384,2
3	Санхүү төрийн сангийн хэлтэс	-	7,2	-	-	7,2
4	Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэс	-	-	-	-	-
5	Хууль, эрх зүйн хэлтэс	-	-	-	-	-
6	Нийгмийн бодлогын хэлтэс	--	-	-	-	
7	Цэргийн штаб	-	49,3			49,3
Дүн		1470,8	2316,4	240,7	232,5	4260,4
Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд						
1	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс		33,0			33,0
2	Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс	11900,0	707,8			12607,8
3	Санхүү төрийн сангийн хэлтэс		5,5			5,5
4	Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэс		6,1			6,1
5	Хууль, эрх зүйн хэлтэс		25,3			25,3
6	Нийгмийн бодлогын хэлтэс	2620,3	2459,6	275,3	10,0	5365,2
7	Цэргийн штаб		4,2			4,2
Дүн		14520,3	3241,5	275,3	10,0	18047,1
Нэгтгэл		15991,1	5557,9	516,0	242,5	22307,5

Зарцуулсан хөрөнгийн хэмжээг нэгжийн түвшинд харьцуулж гаргахад Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсийн хүрээний хариуцсан арга хэмжээний зарцуулалт 72 хувийг эзэлж байна. Энэ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх бүтээн байгуулалтын ажил байна.

№	Агуулга	Бодлогын баримт бичиг болон хуулиар олгосон чиг үүргийн зорилтын хүрээнд	Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд	Дүн
1	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	819.7	33.0	852.7
2	Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс	3384.2	12607.8	15992.0
3	Санхүү төрийн сангийн хэлтэс	7.2	5.5	12.7
4	Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэс	-	6.1	6.1
5	Хууль, эрх зүйн хэлтэс	-	25.3	25.3
6	Нийгмийн бодлогын хэлтэс	-	5365.2	5365.2
7	Цэргийн штаб	49.3	4.2	53.5
Дүн		4260.4	18047.1	22307.5

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас 2022 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянан үзэж өгсөн зөвлөмжид:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний биелэлтийн тайланг хянан үзэхэд, гүйцэтгэлийн төлөвлөгөөг стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээтэй уялдуулаагүй, шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоогүй, хэрэгжилтийн үе шат бүрд бий болох өөрчлөлтийг хэмжих тоон ба чанарын утгыг илэрхийлээгүй, арга хэмжээ бүрийг тоочих байдлаар тайлагнасан, үр дүн, хэрэгжилтийг бүрэн тайлагнаагүй зэрэг дутагдалтай асуудлууд байна гэсний дагуу аймгийн стратеги төлөвлөгөөнд тулгуурлан, шалгуур үзүүлэлтийн суурь болон хүрэх түвшнийг тоо болон хувиар хэмжихээр төлөвлөж, үр дүнг тайлагнахыг чиглэл болгон зөвлөж хэрэгжилтийг тооцож ажиллалаа.

1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилт, арга хэмжээг төлөвлөхдөө бодлогын баримт бичигт тусгагдсан тухайн яамны чиг үүрэгт хамааралтай зорилт, арга хэмжээний хүрээнд төлөвлөж байх;
 - Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт, арга хэмжээг төлөвлөхдөө яамдын сайдтай байгуулсан гэрээнд туссан орон нутагт чиглэсэн арга хэмжээтэй уялдуулан төлөвлүүлж, зөвлөмж өгч ажиллалаа.
2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний явцын байдалд дүн шинжилгээ хийж, зорилтот түвшинд бүрэн хүрээгүй болон тодорхой үр дүн гарч эхэлж байгаа зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэхэд анхаарч, нэгжийн болон албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнтэй уялдуулан дүгнэж, хариуцлагыг сайжруулах;
 - Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээг тус оны 6 сард хийж, зорилт, арга хэмжээний дундаж 90,04

хувьтай, хугацаа болоогүй 15 арга хэмжээ, 0 хувьтай 10 арга хэмжээ байгааг эрчимжүүлж ажиллах чиглэл өгч, зөвлөн тусалж ажилласнаар жилийн эцэст 6,3 хувиар өссөн байна.

3. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Аргачлал, загвар батлах тухай” 100 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнахад тавигдах нийтлэг болон тусгай шаардлагуудад нийцүүлэн хүрсэн үр дүн, үр дүнд хүрээгүй бол шалтгаан, тайлбарыг 2000 тэмдэгтэд багтаан, алдаа мадаггүй товч бөгөөд ойлгомжтой байдлаар тухайн арга хэмжээг хэрэгжүүлснээр хүрсэн үр дүнг тайлагнаж байх;
 - Тус төлөвлөгөөний хэрэгжилтийг 2000 тэмдэгтэд багтаан, алдаа мадаггүй товч, ойлгомжтой байдлаар хүрсэн үр дүнг харуулахуйц тайлагнахыг байгууллагын нэгжийн удирдлага, албан хаагчдад зөвлөмжилж, хэрэгжилтийг тооцохдоо анхаарч ажилласан.
4. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний www.new.unelgee.gov.mn мэдээллийн цахим системд оруулахдаа хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг тодорхой тусгаж, нотлох баримтыг хавсарган, иж бүрэн тайлагнаж байх;
 - Гүйцэтгэлийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан дүгнэлт, нотлох баримтын хамт Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний www.new.unelgee.gov.mn мэдээллийн цахим системд орууллаа.
5. Хууль тогтоомж, бодлого шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хэрэгжилт хангалтгүй болон хэрэгжээгүй арга хэмжээ тус бүрийг хяналтад авч, дараа жилийн төлөвлөгөөнд нэмэлтээр тусган хэрэгжүүлж байх:
 - Хууль тогтоомж, бодлого шийдвэрийн 0-30 хувьтай хэрэгжсэн 15 заалт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 7 арга хэмжээ, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 12 арга хэмжээ, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн 7 арга хэмжээ, хэрэгжилт хангалтгүй болон хэрэгжээгүй арга хэмжээ тус бүрийг хяналтад авчхэрэгжүүлэн ажиллаж, үр дүнг нэмэгдүүлсэн.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүдэд зөвлөмж:

1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд агентлагийн ажил тусгахгүй байх /нэгжүүд өөрсдийн хариуцах ажлаа оновчтой тодорхойлж төлөвлөх/
2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд саналаа хүргүүлэхдээ яамны болон бодлогын баримт бичигтэй уялдуулж, хуулбарлахгүй төлөвлөх
3. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг судлан ажилдаа мөрдлөг болгож зарцуулсан хөрөнгийн тайланг чанартай ирүүлж байх

4. Төлөвлөгөөний биелэлтийг гаргахдаа шалгуур үзүүлэлтийн дагуу, зорилтот түвшинд хүрсэн эсэхийг ойлгомжтой байдлаар, тоо баримттайгаар үр дүнд хүрсэн эсэхийг тодорхой, баримтжуулан тайлагнах
 5. Зарцуулсан төсвийн хэрэгжилтийг тайлагнахдаа сая.төгрөгөөр тоо баримтыг эмх цэгцтэй, эх үүсвэрийг тодорхой, тус туст нь ялгаж тооцож тайлагнах
 6. Арга хэмжээний шалгуурыг хүрэх түвшиндээ хүрсэн эсэхийг тайланд тоон мэдээллээр тусгаж тайлагнах
 7. Төрийн захиргааны удирдлагын хэлтэс нь төлөвлөлт, тайлагналтыг хэлтсүүдээс авч нэгтгэхдээ шаардлага хангасан төлөвлөлт, чанартай тайланг авч байх
 8. ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг хэлтсийн дарга нар хянаж ирүүлж байх
 9. Удаашралтай, үр дүнгүй хэрэгжиж буй арга хэмжээг хяналтдаа авч, удирдлагуудад танилцуулан, цаашид хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, эрчимжүүлж ажиллах
- Цаашид төлөвлөлтийг хийхдээ зорилт, арга хэмжээ 2-ын уялдааг сайн хангах, салбарын бодлоготой уялдуулан шалгуур үзүүлэлтийг бодитой зөв томъёолох шаардлагатай байгааг онцолж байна.

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт санал:

1. Unelgee.mn цахим системд хэрэгжилт, нотлох баримт оруулах боломжоор хангаж, программыг оны эхнээс буюу эхний хагас жилээс нээлттэй байлгах саналыг хүргүүлж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН:

ХЭЛТИЙН ДАРГА

Д. ДААРИЙМАА

ТАЙЛАН БИЧСЭН:

МЭРГЭЖИЛТЭН

Н. ДЭЛГЭРМАА

2024 оны сарын